

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/004/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
О.СИЙЛЭГМАА ТАНАА

2025.02.25 № 07/716
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1, 208 дугаар зүйлийн 208.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сангаас хэрэгжүүлж байгаа тэтгэлгүүд Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөр болон Сангийн санхүүжилтээр магистр, докторын сургалтад хамрагдаж, 6,352,208.0 мянган төгрөгийн зээл, тэтгэлэг авсан нийт 68 суралцагч гэрээний үүргээ зөрчсөн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр 4,558,917.78 ам.доллар, 1,902,319.42 евро, 4,298,444.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан 205 суралцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Аудитын гол асуудал

Тайлант онд дотоодын болон гадаадын их, дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох, эргэн төлөлтийг хянах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Дотоодын их, дээд сургуулийн 16,261 суралцагчид 35,896,373.4 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 2,108 суралцагчид 4,348,566.4 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон;
- Засгийн газрын 2022 оны 346, 2024 оны 102 дугаар тогтоолын дагуу Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэтгэлгээр 2,117 суралцагчид 46,328,942.6 мянган төгрөгийн санхүүжилт, Дэлхийн шилдэг их сургуульд суралцаж буй 149 суралцагчид 11,970,679.1 мянган төгрөгийн зээл олгожээ.
- Эргэн төлөлтийн хүрээнд:
 - Оюутны хөгжлийн зээл авсан 47,062 суралцагчаас 11,528,507.4 мянган төгрөг,
 - Хөнгөлөлттэй зээл авсан 382 суралцагчийн 362,178.0 мянган төгрөг,
 - Гадаадад суралцах зээл авсан 42 суралцагчийн 2,579,287.7 мянган төгрөгийн зээл тус тус эргэн төлөгдсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолын хавсралтаар "Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам", 103 дугаар тогтоолын хавсралтаар "Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ыг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,615,861,132.4	2,200,083,868.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	288,869,374.5	463,202,809.0
33	АВЛАГА	15,892,014.9	47,902,768.5
34	УРЬДЧИЛГАА	513,456.9	566,096.2
35	БАРАА МАТЕРИАЛ	191,131,143.8	234,121,999.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,119,455,142.3	1,454,290,195.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,504,562,884.1	3,818,947,962.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,504,562,884.1	3,818,947,962.1
39200	Биет хөрөнгө	3,303,738,995.5	3,614,282,166.5
39300	Биет бус хөрөнгө	200,823,888.6	204,665,795.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,120,424,016.5	6,019,031,830.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	33,790,507.0	86,739,406.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	33,790,507.0	86,739,406.7
41300	Өглөг	28,129,025.2	83,881,379.0
41400	Урьдчилж орсон орлого	5,661,481.8	2,858,027.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,086,633,509.5	5,932,292,424.1
51	Засгийн газрын хувь оролцоо	5,086,633,509.5	5,932,292,424.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	926,717,646.1	931,341,210.3
51200	Хуримтлагдсан үр дүн	3,162,706,955.1	4,016,005,742.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	997,208,908.3	984,945,471.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,120,424,016.5	6,019,031,830.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,685,699,207.4	4,098,342,464.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	944,582,317.7	655,553,739.4
120	Нийтлэг татварын бус орлого	944,582,317.7	655,553,739.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,741,116,889.7	3,442,788,724.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,496,579,840.3	3,155,041,788.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,496,579,840.3	3,155,041,788.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,259,424,129.6	2,893,255,928.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,461,840,093.3	2,092,848,093.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,900,038.2	259,214,562.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,747,193.1	25,285,949.9
2104	Хангамж, бараа материалын зардал	26,658,258.6	32,559,568.0
2105	Нормативт зардал	109,348,900.5	126,689,127.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,856,992.0	5,371,135.1
2107	Томилолт, зочны зардал	1,056,778.5	939,014.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,564,817.8	60,785,766.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,451,057.4	289,562,711.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	237,155,710.7	261,785,860.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,189,119,367.1	943,300,675.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	172,687.7	243,219.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	216,670,679.7	101,145,222.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	972,621,375.2	842,398,672.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,115,017,296.3	-	4,115,017,296.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(446,779.4)	-	(446,779.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,114,570,516.9	-	4,114,570,516.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(762,859.4)	-	(762,859.4)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	204,476.9	-	204,476.9
9	Тайлант үеийн үр дүн	972,621,375.2	-	972,621,375.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,086,633,509.5	-	5,086,633,509.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,908,638.1	-	5,908,638.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,092,542,147.6	-	5,092,542,147.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,613,936.5)	-	(5,613,936.5)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	3,176,217.9	-	3,176,217.9
17	Өмчид гарсан өөрчлөлт	(213,686.1)	-	(213,686.1)
19	Тайлант үеийн үр дүн	842,401,681.2	-	842,401,681.2
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,932,292,424.1	-	5,932,292,424.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,842,135,704.0	3,609,884,122.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	99,319,284.9	167,830,288.7
120	Нийтлэг татварын бус орлого	99,319,284.9	167,830,288.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,742,816,419.1	3,442,053,834.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,331,008,209.9	2,968,075,947.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,331,008,209.9	2,968,075,947.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,086,080,163.7	2,699,930,946.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,461,909,220.9	2,092,096,449.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	184,252,722.6	259,330,084.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,678,776.3	24,575,742.5
2104	Хангамж, бараа материалын зардал	2,042,094.2	712,789.7
2105	Нормативт зардал	103,049,246.9	120,528,051.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,282,760.2	3,870,078.6
2107	Томилолт, зочны зардал	850,138.5	408,981.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,978,810.1	66,208,551.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,036,393.8	132,200,217.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,928,046.2	268,145,000.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	511,127,494.1	641,808,175.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	354,434,102.9	467,474,741.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	354,434,102.9	467,474,741.2
2200	Дотоод эх үүсвэрээр	354,434,102.9	467,474,741.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(354,434,102.9)	(467,474,741.2)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	156,693,391.1	174,333,434.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,175,983.3	288,869,374.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	288,869,374.5	463,202,809.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
00101 Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	254,381,839,700.00	269,532,739,784.79	(15,150,900,084.79)	106.0
00101_1 Төрийн сан	-	250,304,853,304.23	(250,304,853,304.23)	
00101_2 Арилжааны банк	-	15,220,495,404.48	(15,220,495,404.48)	
00101_5 Урьд оны үлдэгдлээс санхүүжих	254,381,839,700.00	4,007,391,076.08	250,374,448,623.92	1.6
00102 НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,721,047,072,500.00	3,369,589,122,660.52	351,457,949,839.48	90.6
00109 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,721,047,072,500.00	3,369,589,122,660.52	351,457,949,839.48	90.6
00185 Татварын бус орлого	3,721,047,072,500.00	3,369,589,122,660.52	351,457,949,839.48	90.6
00186 Нийтлэг татварын бус орлого	98,924,293,900.00	86,116,845,920.06	12,807,447,979.94	87.1
00190 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	43,567,509,000.00	38,332,078,404.34	5,235,430,595.66	88.0
00191 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	55,356,784,900.00	47,768,481,728.72	7,588,303,171.28	86.3
00196 Бусад орлого	-	16,285,787.00	(16,285,787.00)	
00199 Тусламжийн орлого	3,622,122,778,600.00	3,283,472,276,740.46	338,650,501,859.54	90.7
00200 Хандив тусламж /дотоод/	18,094,674,500.00	16,369,720,931.00	1,724,953,569.00	90.5
00204 Төсвөөс санхүүжих	3,604,028,104,100.00	3,267,102,555,809.46	336,925,548,290.54	90.7
00211 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,975,428,912,200.00	3,269,496,137,075.63	705,932,775,124.37	82.2
00213 УРСГАЛ ЗАРДАЛ	3,270,472,518,900.00	2,864,897,898,871.05	405,574,620,028.95	87.6
00214 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,153,328,382,100.00	2,758,035,280,191.13	395,293,101,908.87	87.5
00215 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,408,125,692,800.00	2,105,025,577,151.37	303,100,115,648.63	87.4
00216 Үндсэн цалин	1,629,218,492,900.00	1,364,201,035,171.31	265,017,457,728.69	83.7
00217 Нэмэгдэл	711,647,911,300.00	615,245,247,336.64	96,402,663,963.36	86.5
00218 Унаа хоолны хөнгөлөлт	5,061,257,900.00	22,294,575,985.46	(17,233,318,085.46)	440.5
00219 Урамшуулал	62,198,030,700.00	102,561,374,424.45	(40,363,343,724.45)	164.9
00220 Гэрээт ажлын хөлс	-	723,344,233.51	(723,344,233.51)	
00221 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	294,175,791,700.00	260,964,660,380.18	33,211,131,319.82	88.7
00222 Тэтгэврийн даатгал	200,040,212,200.00	178,658,246,472.99	21,381,965,727.01	89.3
00223 Тэтгэмжийн даатгал	23,535,903,600.00	21,107,092,295.86	2,428,811,304.14	89.7
00224 ҮОМШӨ-ний даатгал	11,781,496,900.00	10,758,517,130.34	1,022,979,769.66	91.3
00225 Ажилгүйдлийн даатгал	11,761,279,800.00	9,993,248,375.93	1,768,031,424.07	85.0
00226 Эрүүл мэндийн даатгал	47,056,899,200.00	40,447,556,105.06	6,609,343,094.94	86.0
00227 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,470,022,300.00	25,565,774,658.31	904,247,641.69	96.6
00228 Гэрэл, цахилгаан	1,204,393,800.00	1,111,265,937.63	93,127,862.37	92.3

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

00229	Түлш, халаалт	810,998,500.00	784,923,778.92	26,074,721.08	96.8
00230	Цэвэр, бохир ус	445,130,500.00	374,953,474.85	70,177,025.15	84.2
00231	Байрны түрээс	24,009,499,500.00	23,294,631,466.91	714,868,033.09	97.0
00232	Хангамж, бараа материалын зардал	1,942,865,600.00	1,504,221,437.80	438,644,162.20	77.4
00233	Бичиг хэрэг	507,036,000.00	348,524,425.00	158,511,575.00	68.7
00234	Тээвэр, шатахуун	70,178,700.00	51,698,050.00	18,480,650.00	73.7
00235	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,213,400.00	62,003,796.80	1,209,603.20	98.1
00236	Ном, хэвлэл	245,876,700.00	204,092,448.00	41,784,252.00	83.0
00237	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000,000.00	163,660,095.00	36,339,905.00	81.8
00238	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	856,560,800.00	674,242,623.00	182,318,177.00	78.7
00239	Нормативт зардал	150,382,555,700.00	127,746,173,844.08	22,636,381,855.92	84.9
00240	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,388,060,900.00	6,704,219,615.49	683,841,284.51	90.7
00241	Хоол, хүнс	142,822,034,800.00	120,886,082,628.59	21,935,952,171.41	84.6
00242	Нормын хувцас, зөөлөн эдлэл	172,460,000.00	155,871,600.00	16,588,400.00	90.4
00243	Эд хогшил, урсгал засварын зардал	12,734,414,100.00	10,137,794,698.53	2,596,619,401.47	79.6
00244	Багаж, техник, хэрэгсэл	4,230,798,400.00	3,791,305,250.50	439,493,149.50	89.6
00245	Тавилга	4,114,870,100.00	2,287,307,827.00	1,827,562,273.00	55.6
00246	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,089,574,700.00	994,803,967.00	94,770,733.00	91.3
00247	Урсгал засвар	3,299,170,900.00	3,064,377,654.03	234,793,245.97	92.9
00248	Томилолт, зочны зардал	92,757,400.00	70,628,740.40	22,128,659.60	76.1
00249	Гадаад албан томилолт	15,289,200.00	26,491,740.40	(11,202,540.40)	173.3
00250	Дотоод албан томилолт	77,468,200.00	44,137,000.00	33,331,200.00	57.0
00252	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,477,069,100.00	54,154,054,114.17	10,323,014,985.83	84.0
00253	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,174,226,300.00	23,000,100,508.97	2,174,125,791.03	91.4
00254	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,000,000.00	12,000,000.00	3,000,000.00	80.0
00255	Даатгалын үйлчилгээ	10,671,000.00	1,024,731.00	9,646,269.00	9.6
00256	Тээврийн хэрэгслийн татвар	1,123,300.00	970,883.00	152,417.00	86.4
00258	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,233,048,500.00	31,136,120,522.20	8,096,927,977.80	79.4
00259	Газрын төлбөр	3,000,000.00	2,797,469.00	202,531.00	93.2
00260	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	40,000,000.00	1,040,000.00	38,960,000.00	2.6
00262	Бараа үйлчилгээний бусад зардал	194,927,213,400.00	172,866,395,166.29	22,060,818,233.71	88.7
00263	Бараа үйлчилгээний бусад зардал	157,176,223,400.00	137,560,904,836.08	19,615,318,563.92	87.5
00264	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,750,990,000.00	35,305,490,330.21	2,445,499,669.79	93.5
00271	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,144,136,800.00	106,862,618,679.92	10,281,518,120.08	91.2
00280	Бусад урсгал шилжүүлэг	117,144,136,800.00	106,862,618,679.92	10,281,518,120.08	91.2

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

00281	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	-	1,180,776.00	(1,180,776.00)	
00283	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,190,000.00	3,240,000.00	21,950,000.00	12.9
00284	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	89,849,391,300.00	80,585,090,011.48	9,264,301,288.52	89.7
00286	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,380,452,500.00	2,177,249,647.67	203,202,852.33	91.5
00287	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,783,883,100.00	4,538,173,888.00	245,709,212.00	94.9
00288	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,105,219,900.00	19,557,684,356.77	547,535,543.23	97.3
00290	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	704,956,393,300.00	404,598,238,204.58	300,358,155,095.42	57.4
00291	Барилга байгууламж	638,510,178,900.00	371,224,314,416.78	267,285,864,483.22	58.1
	Их засвар	2,811,859,600.00	232,312,747.80	2,579,546,852.20	8.3
	Тоног төхөөрөмж	63,634,354,800.00	33,141,611,040.00	30,492,743,760.00	52.1
00300	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(254,381,839,700.00)	100,092,985,584.89	(354,474,825,284.89)	(39.3)
00301	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,381,839,700.00	(100,092,985,584.89)	354,474,825,284.89	(39.3)
00302	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	254,381,839,700.00	(100,092,985,584.89)	354,474,825,284.89	(39.3)
00342	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	369,625,725,369.68	(369,625,725,369.68)	
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
	Төсвийн байгууллага	1,742	1,742	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,386,558,099.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,386,558,099.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,180,254,865.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		924,706,536.90
210101	Үндсэн цалин		573,864,796.54
210102	Нэмэгдэл		220,891,531.92
210104	Урамшуулал		129,950,208.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		112,155,533.56
210201	Тэтгэврийн даатгал		102,620,486.56
210202	Тэтгэмжийн даатгал		2,383,761.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,191,881.00
210204	Ажилгүйдлийн даатгал		1,191,881.00
210205	Эрүүл мэндийн даатгал		4,767,524.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,080,000.00
210304	Байрны түрээс		2,080,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		42,551,282.94
210401	Бичиг хэрэг		38,637,012.94
210402	Тээвэр, шатахуун		3,914,270.00
2105	Нормативт зардал		14,142,500.00
210502	Хоол, хүнс		9,467,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		4,675,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		97,728,313.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,470,000.00
210602	Тавилга		13,530,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		26,100,000.00
210604	Урсгал засвар		54,628,313.00
2107	Томилолт, зочны зардал		378,226,857.44
210701	Гадаад албан томиллолт		27,088,657.44
210702	Дотоод албан томиллолт		351,138,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		684,295,559.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		684,295,559.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		924,368,282.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		355,288,227.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		569,080,054.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		206,303,233.75
2132	Бусад урсгал шилжүүлэг		82,940,122.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		976,522.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		81,963,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		123,363,111.75
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		123,363,111.75
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		3,286,112,636.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,286,112,636.96
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		752,579,808.83

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		287,129,450.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		795,474,100.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,450,929,277.53
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		(100,445,462.15)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		124,392,190.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		23,946,728.36

3. ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Нийцлийн асуудал

Төвлөрүүлэн захирагчтай холбоотой нийцлийн асуудлаар нийт 11 зөрчил илэрсэнд 6 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгч, сөрөг болон татгалзсан дүгнэлт авсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

1. Боловсролын ерөнхий газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,742 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад "Сөрөг" дүгнэлт өгч, 1 байгууллагад аудит хийхээс татгалзсан байна. Үүнд:

- "Сөрөг" дүгнэлт авсан: Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургууль, Ховд аймгийн Ховд сумын ерөнхий боловсролын сургууль;
- "Татгалзсан" дүгнэлт авсан: Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургууль.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, мөн Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, ...", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг, татгалзсан дүгнэлт авсан төсөв захирагч нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Төсвийн тухай хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд зарим шийдвэрийг гаргаагүйгээс өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэсэн байна. Үүнд:

- 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер, арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлаагүй;
- 2.2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/545 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийг 2023 онд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн шинэчлээгүй;
- 2.3. Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг батлаагүй;
- 2.4. Боловсролын ерөнхий хууль 2023 онд батлагдсантай холбоотойгоор Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлагыг шинэчлэн батлаагүй, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 08 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Төрийн өмчийн 8 мэргэжлийн боловсролын байгууллага магадлан итгэмжлэгдээгүй;
- 2.5. Хүүхэд хамгааллын тухай хууль шинээр батлагдсан боловч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 тушаалын хавсралтаар баталсан "Цэцэрлэгийн

хүүхэд хамгааллын бодлого” болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлаагүй;

- 2.6. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын харьяа чадамжийн төв, салбар дундын дадлагын баазад тавих нийтлэг шаардлагыг батлаагүй;
- 2.7. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавих шаардлага, сургалт зохион байгуулах журмыг батлаагүй;
- 2.8. Мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг боловсруулж батлуулаагүй;
- 2.9. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын зөвлөл нь Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, санд аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлж болох санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг салбарын онцлогт нийцүүлэн тогтоох хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй;
- 2.10. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль 2023 онд батлагдсантай холбоотойгоор Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг шинэчлэн батлаагүй бөгөөд Мэргэжлийн боловсролын байгууллагууд Хөдөлмөрийн сайдын 2015.10.19-ны А/197 тушаалаар баталсан "Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар"-ыг, Техникийн боловсролын байгууллагууд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019.03.28-ны А/134 тушаалаар баталсан "Техникийн боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлага" журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна;
- 2.11. Насан туршийн боловсролын нэгдсэн бодлого, Иргэдийн боловсролын нэгдсэн судалгаа байхгүйгээс шалтгаалан, боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй насан туршийн боловсролын хөтөлбөрүүд нь "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 2.1-ийн хэрэгжилтийг бүрэн хангахгүй байх эрсдэлтэй байна. Тус зорилт нь "Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх" зорилготой. Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2010 оны 556 дугаар тушаалаар баталсан "Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөр", "Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр", "Амьдрах ухааны албан бус боловсролын сургалтын хөтөлбөр", "Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр", "Албан бус болон насанд хүрэгчдийн боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөр", мөн Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирлын 2024 оны А/57 дугаар тушаалаар баталсан "Насанд хүрэгчдэд зориулсан Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн боловсролын сургалтын жишиг хөтөлбөр", Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/88 тушаалаар баталсан "Мэдээллийн технологид суурилсан бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөрүүд" хэрэгжиж байгаа хэдий ч тухайн бодлогын зорилтуудыг бүрэн хангахгүй байх магадлалтай;
- 2.12. Насан туршийн суралцахуйн төвүүд нь гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, санхүүжилтийн тогтолцоонд шилжээгүй;
- 2.13. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдээс 31,400.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 53 төсөл, арга хэмжээний зураг төсөв нь хууль батлагдсаны дараа баталгаажсан бөгөөд үүнтэй холбогдуулан ойролцоогоор 72,900.0 сая төгрөгийн нэмэлт төсөв шаардлагатай нөхцөл байдал үүссэн байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т "Боловсролын санхүүжилтийн тогтолцоо чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан, бие даасан, ил тод, үр ашигтай байх зарчмыг баримтална", 26 дугаар зүйлийн 26.1.6-д "төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий

боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежер, арга зүйч, багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлагыг батлах", 26 дугаар зүйлийн 26.1.20-д "боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны ёс зүйн дүрмийг батлах", 26 дугаар зүйлийн 26.1.3-т "иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах", 26 дугаар зүйлийн 26.1.8-д "хуульд өөрөөр заагаагүй бол мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам болон шинжээчид тавих шаардлага батлах",

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төв, сүм хийдийн шашны сургууль хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна", 23.5-д "Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 23.5.1.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг батлах; 23.5.2.боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх; 23.5.3.боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн сургалтын хөтөлбөрт эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үр чадварыг эзэмшүүлэх агуулга туссан эсэхэд хяналт тавих",

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.12-т "Сургалтын хөтөлбөрт тавих шаардлага, сургалтын хөтөлбөрийн загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 9 дүгээр зүйлийн 9.12-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалдаа чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно", 9.13-т "Энэ хуулийн 9.12-т заасан чадамжийн төв, дадлагын баазад тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 11 дүгээр зүйлийн 11.2-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаанд тавих шаардлага, сургалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", 22 дугаар зүйлийн 22.8-д "Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 22.8.3.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах", 22.8.4-т "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг дэмжих санд аж ахуйн нэгж, байгууллагаас үзүүлж болох санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг салбарын онцлогт нийцүүлэн тогтоох", 23 дугаар зүйлийн 23.1-т "Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 25.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 23.1.2.мэргэжлийн өөрийн өртөг тооцох аргачлалыг санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах",

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.11-т "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах", 27¹ дүгээр зүйлийн 27¹.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд нь энэ хуулийн 11.1.23-т заасан аргачлалын дагуу улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээний нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгсөн төслүүд байна", 27¹.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн урьдчилсан үнэлгээнд оруулах төслийн саналыг энэ хуулийн 11.1.23-т заасан аргачлалын дагуу бэлтгэж, жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын ерөнхий хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд зарим шийдвэрийг гаргаагүйгээс өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын

хэвийн үйл ажиллагаанд эрсдэл үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Боловсролын байгууллагын урамшуулал, нэмэгдэл, хөлсний зохицуулалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн давхардал, хийдэл, уялдаа холбоогүй байдал нь бодлого, санхүүгийн хэрэгжилтэд зөрчил, эрсдэл үүсгэж байна. Үүнд:

- 3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн төсөв гүйцэтгэл 2019 оноос үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор зөвхөн үнэлгээ сайтай багш, байгууллагын ажилтнууд урамшуулал авах зохицуулалт хэрэгжиж эхэлсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 25, 39 дүгээр тогтоолоор байгууллагын болон багшийн үнэлгээний урамшууллыг зохицуулсан. Гэвч Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, 2022 оны 252 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн багш, туслах багш, ажилтнуудад улирлын үр дүнгийн урамшуулал олгох заалт хүчин төгөлдөр хэвээр байгаа нь урамшууллыг давхардуулах, гүйцэтгэл муутай багш, ажилтнуудад урамшуулал олгох, цаашлаад төсвийн үр ашиггүй зарцуулалт бий болох зэрэг эрсдэл үүсгэж байна;
- 3.2. Хүн ам, хөдөлмөрийн сайд болон Сангийн сайдын 1996 оны 63/104 тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-аар зарим харьяа байгууллага ажилчдын ур чадварын нэмэгдлийн асуудлыг зохицуулсан байна. Гэвч энэхүү журам нь боловсролын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн зарим баримт бичгүүдтэй нийцэхгүй байна;
- 3.3. Боловсролын салбарт зэрэгцсэн болон хавсран гүйцэтгэх хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтан, мөн тэтгэвэр тогтоолгосон боловч ажлаа үргэлжлүүлэн хийж байгаа ажилтанд олгох нэмэгдэл, урамшуулал, илүү цагийн хөлсний талаар Хөдөлмөрийн дотоод журамд нарийвчилсан зохицуулалтгүй, нэгдсэн удирдамж, чиглэл байхгүйгээс харьяа байгууллагууд уг зардлыг ялгамжтай тогтоон олгож байна;
- 3.4. Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/2772 дугаар бүхий албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу байгууллагын даргын тушаалаар төсөв захирагч, нягтлан бодогч, нярав нарт балансын урамшуулал тооцон олгосон нь улирал бүрийн үр дүнгийн урамшуулалтай давхардал үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна.”, 20.1.2-т “нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон хууль тогтоомжид харшилсан шийдвэрийг биелүүлэхээс татгалзах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д “Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урамшуулал, нэмэгдэл, хөлсний зохицуулалттай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн давхардал, хийдэл, уялдаа холбоогүй байдал нь бодлого, санхүү төсвийн үйл ажиллагааны хэрэгжилтэд зөрчил, эрсдэл үүсгэж байгаа асуудлыг судалж, дүн шинжилгээ хийгээд Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан шийдвэрлүүлэх, зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

4. Өмнөх аудитаар өгсөн “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолын дагуу төрийн өмчийн 685 ерөнхий

боловсролын сургуулийн үдийн хоолны үйлчилгээг 2024 онд сургуулийн үйл ажиллагааны чиглэлд бүрэн шилжүүлсэн байхаар зохицуулсан боловч одоогийн байдлаар 75 ерөнхий боловсролын сургууль хувийн хэвшлийн байгууллагаар үдийн хоолны үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлдэг, стандартад нийцсэн байр, гал тогоо, тоног төхөөрөмж болон орон тоо, цалингийн зардлын асуудлаас шалтгаалан тус хууль болон тогтоолын заалт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна” зөрчилд өгсөн зөвлөмж дутуу хэрэгжсэн ба эрсдэл байсаар байна;

5. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулиар сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллахаар зохицуулсан боловч орон тооны норматив батлагдаагүй байна.

Энэ нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлага хангасан зориулалтын байр, гал тогоо, тоног төхөөрөмж ашиглан мэргэжлийн хүний нөөцтэйгөөр явуулна", 6.5-д "Сургуульд хоол зүйч, мэргэжлийн тогооч, туслах тогооч ажиллах бөгөөд суралцагчийн тооноос хамаарч бэлтгэгч, угаагч, үйлчлэгч ажиллана", 10 дугаар зүйлийн 10.7-д "Сургуулийн захирал сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:", 10.7.1-д "хоол зүйч, тогоочийг давтан сургах", 10.7.3-д "сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулах;", 10.7.4-д "сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад шаардлагатай зардлын хуваарилалтыг шийдвэрлүүлэх;", 10.7.5-д "сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах энэ хуулийн 6.5-д заасан ажилтныг томилох, чөлөөлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны үйлчилгээг сургуулийн үйл ажиллагааны чиглэлд шилжүүлээгүй, орон тооны нормативыг батлаагүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

6. Иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих суралцахуйн удирдлагын системгүй байгаа нь Боловсролын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т "Иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих суралцахуйн удирдлагын системтэй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэдийн насан туршийн суралцахуйг дэмжих суралцахуйн удирдлагын системгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

7. Ерөнхий боловсролын 28 сургуулийн барилгыг Мэргэжлийн хяналтын газраас акталсан дүгнэлт гаргасан боловч ашигласаар байгаа нь тус сургуулийн багш, ажилтнууд, суралцагчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэргэжлийн хяналтын газраас акталсан дүгнэлт гаргасан барилгыг ашигласаар байгаа нь тус сургуулийн багш, ажилтнууд, суралцагчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж байгаа зөрчлийг судалж, дүн шинжилгээ хийгээд, тайланг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, үе шаттайгаар шийдвэрлүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

8. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4-д "Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох" зорилтын хүрээнд нийт 787 объектын ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж ажил эхэлсэн байна. Төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдсөн, нийт 4 аймгийн 10 сумын 26 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ: 48.2.7.худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

9. Гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, санхүүжилтийн тогтолцоонд шилжсэн боловсролын салбарын хүүхдийн тоо цөөнтэй байгууллагуудын санхүүжилт нь хэвийн үйл ажиллагааг хангах боломжгүй байгаагаас дутуу санхүүжилтийг төсвийн зохицуулалтаар нөхөн олгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүр, журам батлах тухай” 466 дугаар тогтоол, 2024 оны “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай” 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгууллагын байршил болон суралцагчийн тооны итгэлцүүрээр тооцон олгож буй санхүүжилтийн хэмжээнд судалгаа, дүн шинжилгээ хийж, судалгааны дүн, тайланг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, шаардлагатай зохицуулалтыг хийлгэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн.

10. Боловсролын салбар 2019 оноос гүйцэтгэлд суурилсан төсөвлөлт, санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор зардлын бүтэц, үйл ажиллагаанд өөрчлөлт орсон. Үүнтэй уялдан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 тушаалаар батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага болон боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив нь өнөөгийн шаардлагад нийцэхгүй болсон байна. /Тухайлбал хүний нөөцийн ажилтан, цахим технологи, мэдээллийн ажилтан, мужаан, слесарь, дотоод хяналтын ажилтан, ХАБ-ын орон тооны асуудал шийдэгдээгүй/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага болон боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативын судалгаа, дүн шинжилгээ хийж, судалгааны дүн, тайланг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, шаардлагатай зохицуулалтыг хийлгэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх зөвлөмж өгсөн.

11. Боловсролын ерөнхий газраас Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад “Эй Плас Интернэйшнл” ХХК-тай гэрээ байгуулан ажиллах чиглэл өгч, батлагдсан сургалтын зардлын 60 хувийг тус компанийн сургалтад зарцуулахыг үүрэг болгосон бөгөөд багш нарын сургалтын ирцийг гүйцэтгэлийн үр дүнтэй нь шууд холбосон байна. Үүний хүрээнд тус компанитай “Багшийн хөгжлийг дэмжих модуль сургалтыг цахим платформоор зохион байгуулах” гэрээг 2022 оноос хойш дараалан 3 жил байгуулсан бөгөөд сургалтын төлбөрийг урьдчилан 100 хувиар олгодог, байгуулсан гэрээнүүд нь дүгнэдэггүй зэрэг нь тодорхой нэг компанийн үйл ажиллагааг бодлогоор дэмжсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн

захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Эй Плас Интернэйшнл" ХХК-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнгийн судалгаа хийх, бусдад давуу байдал олгосон аливаа шийдвэр гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

12. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын 692 сургууль, 1003 цэцэрлэг, 41 мэргэжлийн боловсролын байгууллагын нийт 2534 барилга байгууламжаас 322 нь сургалтын орчны стандартад нийцээгүй байна. Үүнээс ерөнхий боловсролын сургуулийн 1088 барилгаас 103, цэцэрлэгийн 1370 барилгаас 207, мэргэжлийн боловсролын байгууллагын 76 барилгаас 12 нь стандартын шаардлага хангахгүй байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Стандартын шаардлага хангахгүй барилгуудыг үе шаттайгаар шинэчлэх, их засвар хийх, шинээр барих төлөвлөгөө боловсруулах, Сургалтын орчны аюулгүй байдлыг хангах түр хугацааны арга хэмжээ авах, Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг оновчтой хуваарилж төсвийн төсөлд тусгах, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, Барилгын ашиглалт, техникийн үзлэгийг тогтмол хийж, хяналтын тогтолцоог сайжруулах, Сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, боловсролын байгууллагын хамтын оролцоог нэмэгдүүлэх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дээр дурдсан албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгсөн асуудлууд нь Төсвийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох зарим шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.2 Санхүүгийн тайлагналтай холбоотой аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Боловсролын салбарын хөрөнгө оруулалт, барьцаа, техник хяналт, Ариун цэврийн байгууламж, Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Насан туршийн боловсролын байгууллагын гүйцэтгэл, үр дүнгээр олгох санхүүжилтийн дансыг түүвэрт хамруулан шалгалаа.

Аудитаар Төсвийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 330,447.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 607.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 179,566.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 150,273.1 сая төгрөгийн зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

3.2.1 Төлбөрийн акт

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалсан боловч үлдэгдэл санхүүжилт 607.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын барьцаа хөрөнгийн дансанд хугацаа хэтрүүлэн байршуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаа хэтэрсэн, гэрээ цуцалсан төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг Төсвийн тухай хууль зөрчин төсөвт төвлөрүүлээгүй барьцаа хөрөнгийн дансанд байршуулж байгаа зөрчилд улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2.2 Албан шаардлага

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдсөн нийт 168,119.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 42 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

- Боловсролын сайдын хяналт тавих нийт 59,569.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 47 төсөл арга хэмжээ,
- Аймгийн засаг даргын хяналт тавих нийт 10,004.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 16 төсөл арга хэмжээ,
- Нийслэлийн Засаг даргын хяналт тавих нийт 11,153.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын 15 төсөл арга хэмжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон гэрээний үүрэг зөрчигдсөн, хөрөнгө оруулалтын арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд их засварын ажлаар тусгагдсан Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Сүмбэр баг дахь бага сургуулийн барилгын өргөтгөлийн их засварын 172.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг Төрийн худалдан авах ажиллагааны газраас модон байшингийн зураг төсөвтэйгөөр тендер зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулж, барилгын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Мөн Онцгой ерөнхий байдлын газраас уг ажил Магадлалын нэгдсэн дүгнэлтээр баталгаажих боломжгүй талаар мэдэгдсэн тул гэрээг эцэслэн дүгнээгүй, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлээгүй, гэрээний алданги төлж үр ашиггүй зардал гаргах эрсдэлийг бий болгосон байна.

Энэ нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх; 14.2.8.хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж ажиллаагүй, үр ашиггүй зардал гарах эрсдэл бий болгосон зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд гэрээнд заасан хугацаанд багтаан ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн нийт 11,274.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл арга хэмжээний барилгын ажлын гэрээг дүгнээгүй, гэрээнд заасны дагуу алданги суутган тооцоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-т “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:48.2.7.худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх”, Засгийн газрын 2023 оны 290 дүгээр “Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2-т “Гэрээний хугацаанд багтаан ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн зарим барилгын ажлын гэрээг дүгнэж, гэрээнд заасны дагуу алданги тооцох, шаардлагатай бол гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна..

Шийдвэрлэсэн нь: Ашиглалтад оруулах боломжгүй нөхцөл үүссэн 5 төсөл арга хэмжээний барилгын ажлын гэрээг дүгнээгүй, гэрээнд заасны дагуу алданги суутган тооцоогүй, зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсөв хүрэлцээгүй байгууллагуудын санхүүжилтийг нөхөх зорилгоор журам зөрчин Боловсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 дугаар тушаалаар батлагдсан төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан 92,211.5 сая төгрөгийг 1000 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад шилжүүлсэн байна.

2. Төсөв хүрэлцээгүй, байгууллагуудын санхүүжилтийг нөхөх зорилгоор журам зөрчин Боловсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 дугаар тушаалаар батлагдсан төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан 58,003.3 сая төгрөгийг 684 Ерөнхий боловсролын сургуульд шилжүүлсэн байна.

3. Төсөв хүрэлцээгүй байгууллагуудын санхүүжилтийг нөхөх зорилгоор журам зөрчин Боловсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 дугаар тушаалаар батлагдсан төсвийн хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулан 58.2 сая төгрөгийг 29 Насан туршийн боловсролын төвд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар

болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийн учир шалтгааныг судалж, системтэй арга хэмжээ авах, хариуцлагын тогтолцоо, санхүүгийн удирдлагын дотоод хяналтыг сайжруулах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ТОО

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн нэгтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 1742 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 898 байгууллагад дүгнэлт гаргаж, 844 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамруулсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” 834, “Хязгаарлалттай” 62, “Сөрөг” 2 дүгнэлт өгч, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Үүнээс Говь-Алтай аймгийн Цогт сумын Ерөнхий боловсролын сургууль, Ховд аймгийн Ховд сумын Ерөнхий боловсролын сургууль “Сөрөг” дүгнэлт, Ховд аймгийн Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургууль “Татгалзсан” дүгнэлт өгсөн.

Аймгийн болон байгууллагын нэр	Нэгтгэсэн байгууллагын тоо	2024 оны санхүүгийн тайлангийн аудит			Дүгнэлт					
		ҮАГ	АНТАГ	АХЭ	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт гаргахаас татгалзсан	Түүвэрт	Аудитад хамрагдаагүй
Архангай	66		7	59	55	4			7	
Баян-Өлгий	98		50	48	58	3			37	
Баянхонгор	68		40	28	29	3			36	
Булган	46		2	44	44	1			1	
Говь-Алтай	61		42	19	21	3	1		36	
Говьсүмбэр	13		2	11	12				1	
Дархан-Уул	49		1	48	47	2				
Дорноговь	59		6	53	53				6	
Дорнод	55		34	21	14	8			33	
Дундговь	43		23	20	22				21	
Завхан	69			69	68	1				
Нийслэл	473		473		3				470	
Орхон	49		22	27	36	1			12	
Өвөрхангай	81		46	35	35				46	
Өмнөговь	55		17	38	42	1			12	
Сүхбаатар	42		19	23	26	1			15	
Сэлэнгэ	75		2	73	62	11			2	
Төв	73		39	34	33	4			36	
Увс	60		39	21	26	2			32	
Ховд	60		53	7	21	11	1	1	26	
Хөвсгөл	77		2	75	76				1	
Хэнтий	64		21	43	47	4			13	
Барилгын Политехник Коллеж	1			1	1					
Боловсролын ерөнхий газрын аппарат	1	1				1				
Монгол Солонгосын политехник коллеж	1			1	1					
Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	1	1							1	

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Налайх дүүрэг дэх Политехник коллеж	1			1	1					
Үйлдвэрлэл урлалын политехник коллеж	1			1	1					
Боловсролын ерөнхий газрын төвлөрүүлэн захирагч	1	1				1				
Нийт	1743	3	940	800	834	62	2	1	844	

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 108.0 сая төгрөгийн 1474 алдаа илэрсний 107.1 сая төгрөгийн 1415 алдааг аудитын явцад залруулж, залруулаагүй үлдсэн 0.9 сая төгрөгийн 59 алдаанд зөвлөмж өглөө.

Аймаг, Нийслэл, байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай	22	4,300,192.1		-	22	4,300,192.1	22	4,300,192.1		-		-
Баян-Өлгий	111	30,705,080.0	27	15,381,778.6	84	15,323,301.4	111	30,705,080.0		-	0	-
Баянхонгор	25	837,786.4	11	126,127.5	14	711,658.9	25	837,786.4		-		-
Булган	96	8,444,517.3	32	279,652.5	64	8,164,864.8	95	8,434,517.3	1	10,000.0	1	10,000.0
Говь-Алтай	56	640,810.1	5	38,425.7	51	602,384.4	56	640,810.1		-		-
Говьсүмбэр	32	667,365.2	8	100,929.5	24	566,435.7	32	667,365.2		-		-
Дархан-Уул	45	887,521.8	18	351,606.7	27	535,915.1	45	887,521.8		-	0	-
Дорноговь	54	6,019,825.7	1	14,500.0	53	6,005,325.7	54	6,019,825.7		-		-
Дорнод	28	864,794.7	9	112,044.6	19	752,750.2	28	864,794.7		-		-
Дундговь	53	2,128,664.3	18	298,077.8	35	1,830,586.5	53	2,128,664.3	0	-		-
Завхан	24	1,535,011.2	4	42,428.9	20	1,492,582.2	24	1,535,011.2		-		-
Орхон	61	3,209,092.3	4	289,403.1	57	2,919,689.2	61	3,209,092.3		-	0	-
Өвөрхангай	35	342,178.5	15	32,153.7	20	310,024.8	35	342,178.5		-		-
Өмнөговь	85	4,650,119.5	10	984,629.8	75	3,665,489.7	85	4,650,119.5		-		-
Сүхбаатар	7	83,610.4	2	45,693.1	5	37,917.3	7	83,610.4		-		-
Сэлэнгэ	128	2,524,177.5	43	684,213.7	85	1,839,963.8	124	2,080,491.7	4	443,685.8	4	443,685.8
Төв	210	12,711,153.5	63	1,729,842.2	147	10,981,311.3	191	12,711,153.5	19	-	19	-
Увс	20	385,596.3	7	262,523.9	13	123,072.4	20	385,596.3		-		-
Ховд	57	3,205,842.5	18	2,087,131.0	39	1,118,711.5	57	3,205,842.5	0	-	0	-
Хөвсгөл	47	567,204.6	8	67,253.1	39	499,951.5	12	86,574.4	35	480,630.2	35	480,630.2
Хэнтий	41	590,055.6	14	118,056.9	27	471,998.7	41	590,055.6	0	-		-
Нийслэл	229	22,242,443.0	95	10,911,286.9	134	11,331,156.1	229	22,242,443.0	0	-	0	-
Барилгын Политехник Коллеж	6	214,360.9	1	1,800.0	5	212,560.9	6	214,360.9		-		-
Налайх дүүрэг дэх Политехник коллеж	2	253,977.3		-	2	253,977.3	2	253,977.3		-		-
Бүгд	1474	108,011,380.6	413	33,959,559.1	1061	74,051,821.5	1415	107,077,064.6	59	934,316.0	59	934,316.0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар нийт 367,234.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,908.0 сая төгрөгийн 637 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 196,638.2 сая төгрөгийн 852 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 168,353.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1371 зөвлөмжийг хүргүүлж, 334.6 сая төгрөгийн 18 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

Аймаг, Нийслэл, байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Дүн	Тоо	Дүн
Архангай	145	1,844,849.9	15	27,300.8	50	352,027.6	80	1,465,521.5					
Баян-Өлгий	207	2,208,236.6	19	64,327.7	80	1,516,271.3	99	486,940.1	9	10	140,697.4	0	-
Баянхонгор	102	323,437.7	38	62,097.3	60	187,839.3	4	73,501.1	0	0	-	0	-
Булган	139	431,390.1	56	38,927.3	21	134,735.8	61	74,467.5	1	1	183,259.5		
Говь-Алтай	152	912,295.1	57	102,665.8	77	586,384.6	18	223,244.7					
Говьсүмбэр	26	69,247.9	13	29,508.5	6	20,275.3	7	19,464.2					
Дархан-Уул	98	623,688.8	27	37,767.0	41	378,532.3	30	207,389.6					
Дорноговь	64	172,053.6	2	2,232.3	10	10,372.3	52	159,449.0					
Дорнод	96	839,506.0	21	76,565.3	66	758,225.8	9	4,714.9					
Дундговь	77	447,768.2	14	34,163.0	53	274,067.7	10	139,537.5					
Завхан	98	5,363,033.4	27	47,921.7	3	21,727.3	68	5,293,384.4					
Орхон	238	898,935.6	107	156,627.5	98	660,221.4	33	82,086.7					
Өвөрхангай	68	2,633,117.6	1	13,537.3	63	2,615,347.0	4	4,233.3					
Өмнөговь	65	1,345,125.6	4	6,879.9	25	532,003.8	36	806,241.9					
Сүхбаатар	81	240,525.0	8	32,115.3	27	170,381.6	46	38,028.1					
Сэлэнгэ	173	832,465.0	45	90,123.7	68	378,930.1	54	352,759.8	6	6	10,651.4		
Төв	222	1,079,467.8	53	97,608.4	32	253,329.2	137	728,530.2					-
Увс	56	1,020,011.5	8	11,349.4	3	9,655.8	45	999,006.3					
Ховд	162	1,940,519.6	68	271,880.5	5	161,458.7	87	1,507,180.4	2	2	-		
Хөвсгөл	169	621,485.7	15	4,914.1	2	5,780.0	152	610,791.6					

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Хэнтий	62	318,139.2	27	58,278.8	33	258,006.5	2	1,853.9					
Нийслэл	350	5,603,831.0	7	21,943.6	17	1,247,047.0	326	4,334,840.5	0	0	-	0	-
Барилгын Политехник Коллеж	4	21,185.6		-	2	19,118.8	2	2,066.8					
Боловсролын ерөнхий газрын аппарат	6	6,926,346.3		-	4	6,490,418.4	2	435,927.9					
Монгол Солонгосын политехник коллеж	4	30,653.8		-	2	19,592.6	2	11,061.2					
Налайх дүүрэг дэх Политехник коллеж	5	17,787.1	2	3,968.1	1	9,932.8	2	3,886.2					
Үйлдвэрлэл урлалын политехник коллеж	4	22,112.6	2	7,780.6		-	2	14,332.0					
Харьяа байгууллагуудын нийт зөрчил	2873	36,787,216.4	636	1,300,483.9	849	17,071,683.1	1370	18,080,441.0	18	19	334,608.4	0	-
Боловсролын ерөнхий газрын төвлөрүүлэн захирагч	5	330,447,237.7	1	607,570.4	3	179,566,505.5	1	150,273,161.8					
Бүгд	2878	367,234,454.1	637	1,908,054.3	852	196,638,188.6	1371	168,353,602.8	18	19.0	334,608.37	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 80,457.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 9.1 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,821.3 сая төгрөгийн 231 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 55,402.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1049 зөвлөмжийг хүргүүлж, 224.2 сая төгрөгийн 11 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

Аймаг, Нийслэл, байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Дүн	Тоо	Дүн
Архангай	9	-		-	9	-		-			-		
Баян-Өлгий	40	5,995,685.4	1	90.0	3	1,378,561.9	35	4,609,738.4	1	1	7,295.1		
Баянхонгор	20	1,376,406.1		-	19	1,376,406.1		-	1	1	-		
Булган	38	3,213,132.7	1	400.0	19	3,114,742.2	18	97,990.5			-		
Говь-Алтай	3	-		-	1	-	2	-			-		
Говьсүмбэр	7	633,140.5		-	1	900.0	5	415,326.3	1	1	216,914.1		

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дархан-Уул	57	451,678.1		-	2	257,804.0	54	193,874.1	1	1	-		
Дорноговь	21	1,171,451.8		-	6	877,281.4	15	294,170.4			-		
Дорнод	33	2,896,722.7		-	25	2,401,334.0	8	495,388.6			-		
Дундговь	40	117,563.5		-	32	100,231.4	5	17,332.1	3	4	-		
Завхан	9	216,336.6		-		-	9	216,336.6			-		
Орхон	24	548,275.9		-	6	336,529.4	18	211,746.5			-		
Өвөрхангай	22	5,389,934.8		-	19	5,194,359.3	3	195,575.5			-		
Өмнөговь	21	2,572,687.4		-	18	2,572,687.4	3	-			-		
Сүхбаатар	14	-		-		-	13	-	1	1	-		
Сэлэнгэ	44	-		-	25	-	18	-	1	1	-		
Төв	61	12,979,745.9	0	-	10	4,169,692.8	50	8,810,053.1	1	1	-	0	-
Увс	12	9,584,647.5		-	2	1,771,274.9	10	7,813,372.6			-		
Ховд	19	1,077,149.8	0	-	0	-	19	1,077,149.8	0	0	-		
Хөвсгөл	99	347,674.8	8	8,634.9	2	146,109.0	89	192,930.8			-		
Хэнтий	8	1,135,481.9		-	7	1,039,597.5	1	95,884.4			-		
Нийслэл	682	30,749,432.8	0	-	16	83,828.8	666	30,665,604.0	0	0	-	0	-
Барилгын Политехник Коллеж	3	-		-	2	-	1	-			-		
Үйлдвэрлэл урлалын политехник коллеж	1	-		-		-	1	-			-		
Монгол Солонгосын политехник коллеж	1	-		-	1	-		-			-		
Налайх дүүрэг дэх Политехник коллеж	2	-		-		-	2	-			-		
Харьяа байгууллагуудын нийт зөрчил	1290	80,457,147.9	10	9,124.9	225	24,821,340.1	1045	55,402,473.7	10	11	224,209.2	0	-
Боловсролын ерөнхий газрын төвлөрүүлэн захирагч	11	-	0	-	6	-	4	-	1	3	-	0	-
Бүгд	1301	80,457,147.9	10	9,124.9	231	24,821,340.1	1049	55,402,473.7	11	14	224,209.2	0	-